



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/280

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.11, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын шийдвэрээр 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Хархорин сумын түүхийг харуулсан аялал жуулчлалын видео контент бүтээх зардалд 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх шаардлагатай санхүүжилтийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Мөнхбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0574

D:My Doc. Zahiramj. Zasag darga